



“МОНГОЛ ЦЭРГИЙН НЭГДСЭН ХОЛБОО”-НЫ САЛБАР ХОЛБООГ ДУНДГОВЬ АЙМАГТ БАЙГУУЛЛАА

[ЭХЛЭЛ](#) / [ДУНДГОВЬ](#)



ШИНЭ МЭДЭЭ

[ИХ УНШСАН](#)



МЭДЭЭ
УОК ЦАХИМААР ХУРАЛДЛАА
3 хоногийн өмнө



МЭДЭЭ
ХАЛДВАРТАЙ ИРГЭНИЙ ОЙРЫН БОЛОН ДАМ...
3 хоногийн өмнө



МЭДЭЭ
ЗАХ ХУДАЛДААНЫ ТӨВҮҮДЭД ХЯНАЛТ...
4 хоногийн өмнө



МЭДЭЭ
ХИЛЭЭР НЭВТРЭХ АЧАА ЭРГЭЛТИЙГ ТҮРГЭСГЭХ...
4 хоногийн өмнө



МЭДЭЭ
ГАЗАР ХӨДЛӨЛТИЙГ УРЬДЧИЛАН МЭДЭЭЛЭХ...
4 хоногийн өмнө



МЭДЭЭ
АЖЛЫН БАЙРЫГ ДЭМЖИХ ХҮРЭЭНД 525 ТЭРБУМ...
5 хоногийн өмнө



МЭДЭЭ
ШАДАР САЙД СХД-ИЙН ШИНЭ ЭМНЭЛЭГТ...
1 долоо хоногийн өмнө

“МОНГОЛ ЦЭРГИЙН НЭГДСЭН ХОЛБОО”-НЫ САЛБАР ХОЛБООГ ДУНДГОВЬ АЙМАГТ БАЙГУУЛЛАА

ДУНДГОВЬ / 7 сарын өмнө

Цэрэг, эх оронч, Үндэсний үзэл бахархлыг хөгжүүлэн, ард түмнээ соён гэгээрүүлж, Монгол улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлын оюуны дархлаа, үнэт зүйлсийг хамгаалан бэхжүүлэх үйлст төр, иргэний нийгмийн байгууллагууд, цэргийн үүрэгтнүүд, иргэдийг нэгтгэх зорилго бүхий “Монгол цэргийн нэгдсэн холбоо”-ны салбар холбоог өнөөдөр Дундговь аймагт байгууллаа.

Энэ үеэр “Монгол цэргийн нэгдсэн холбоо”-ны Дундговь аймаг дахь салбар холбооны тэргүүнээр зуун хувийн саналаар аймгийн Засаг дарга О.Бат-Эрдэнэ, зөвлөх, нарийн бичгийн даргаар хурандаа Б.Амаржаргал нар сонгогджээ. Түүнчлэн салбар холбооны бага хурлыг зохион байгуулж, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгон, цаашдын зорилго, зорилтоо тодорхойлохоор тогтов.

Салбар холбоо байгуулах ёслолын ажиллагаанд аймгийн Засаг дарга О.Бат-Эрдэнэ, “Монгол цэргийн нэгдсэн холбоо”-ны зөвлөх, ажлын хэсгийн дарга, бригадын генерал Д.Ганбаатар, “Монгол цэргийн нэгдсэн холбоо”-ны зөвлөлийн гишүүн, цагдаагийн хурандаа Ц.Бумнанжид, “Монгол цэргийн нэгдсэн холбоо”-ны зөвлөлийн гишүүн, доктор Ж.Цогтсугар, Онцгой байдлын ерөнхий газрын ахмадын зөвлөлийн төлөөлөгч, хурандаа М.Сүхбаатар, “Монгол цэргийн нэгдсэн холбоо”-ны ажлын албаны ажилтан, хурандаа Л.Болдбаатар болон орон нутаг дахь төрийн цэргийн байгууллагын удирдлагууд, тэтгэвэр, чөлөөнд байгаа ахмадууд оролцсон юм.

Мөн гавьяаны амралтдаа гарсан алба хаагчдаа шагнан урамшуулж, шагналыг гардуулан өгчээ. Ёслолын ажиллагаанд Төв халхын дуулалт жүжгийн театрын уран бүтээлчид оролцож, уран бүтээлийнхээ дээжээс өргөн барилаа.

Tweet Like Share Be the first of your friends to like this.

МЭДЭЭ
БОЛОН БАЙДЛААНЫ...

“Монгол цэргийн нэгдсэн холбоо” салбар хороогоо байгууллаа

ОРОН НУТАГТ | ДУНДГОВЬ



Дундговь /МОНЦАМЭ/. “Монгол цэргийн нэгдсэн холбоо” Дундговь аймагт салбар хороогоо байгуулж, энэ сарын дөрөвний өдөр анхдугаар чуулганаа зохион байгууллаа.

“Монгол цэргийн нэгдсэн холбоо”-ны орон нутгийн салбар холбоог байгуулснаар Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлын дархлаа, үнэт зүйлс, орон нутгийн хөгжлийн асуудлыг хүүхэд залуучуудад таниулан ойлгуулах, төлөвшүүлэх, эх оронч үзэл санааг суулгаж өгөх зорилготой ажээ. “Монгол цэргийн нэгдсэн холбоо”-ны салбар хорооны анхдугаар чуулганд аймгийн Засаг дарга О.Бат-Эрдэнэ, “Монгол цэргийн нэгдсэн холбоо”-ны зөвлөх, ажлын хэсгийн дарга, бригадын генерал Д.Ганбаатар, тус холбооны зөвлөлийн гишүүн, цагдаагийн хурандаа Ц.Бумнанжид, доктор Ж.Цогтсугар, ажлын албаны ажилтан, хурандаа Л.Болдбаатар, ОБЕГ-ын ахмадын зөвлөлийн төлөөлөгч, хурандаа М.Сүхбаатар болон орон нутаг дахь тусгай чиг үүрэг бүхий байгууллагын удирдлага, бие бүрэлдэхүүн, чөлөөнд гарсан ахмадууд оролцсон байна.

Тус чуулганаар “Монгол цэргийн нэгдсэн холбоо”-ны Дундговь аймаг дахь тэргүүнээр ймгийн Засаг дарга О.Бат-Эрдэнийг, нарийн бичгийн даргаар хурандаа Б.Амаржаргалыг сонгож, холбооны туг, батламжийг гардуулан өглөө.

Мөн гавьяаны амралтад гарсан алба хаагчдаа шагнан урамшуулж, Төв халхын дуулалт жүжгийн театрын уран бүтээлчид уран бүтээлийн дээжээс өргөн барьжээ.

